



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/50

Ховд

Захирамжийн заалт хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Орон тооны зохицуулалтын тухай” А/129 дүгээр захирамжийн 3, 4 дүгээр заалтуудыг хүчингүй болгосугай.

2. Хүчингүй болгож буй заалтуудтай холбоотой зохицуулалтыг Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн холбогдох заалт болон зохих тогтоол, журамд нийцүүлж ажиллахыг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ДҮГЭРЖАВ

